

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ХОВД СУВРАГА ОНӨААТҮГ-ЫН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/3/СТА-ОНӨААН

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: BoldbaatarKh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsurena@audit.gov.mn Аудитор: Ц.Аззаяа Утас: 70432545 цахим хаяг: Azzaya.Ts@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
АОУС	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
УСНББОУС	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
ТТЗ	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
ТШЗ	<i>Төсвийн шууд захирагч</i>
НББББ	<i>Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг</i>
ЗДТГ	<i>Засаг даргын дамгын газар</i>
ОНХС	<i>Орон нутгийн хөгжлийн сан</i>
СӨБ	<i>Сургуулийн өмнөх боловсрол</i>
БСШУЯ	<i>Боловсрол соёл шинжлэх ухааны яам</i>

Агуулга

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	төгрөгөөр5
2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН	төгрөгөөр.....6
2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	төгрөгөөр6
2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН.....	7
3.АУДИТЫН ТАЙЛАН	7
3.1. Ерөнхий зүйл.....	7
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	7
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	8
3.4. Материаллаг байдал	8
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	8
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	Error! Bookmark not defined.
3.7. Шилэн дансны мэдээлэл	9
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	9
3.9. Аудитын илрүүлэлт	10
Залруулсан алдаа: Аудитаар залруулсан алдаа байхгүй болно.	10
Аудитын зөвлөмж: Аудитаар илэрсэн 1 алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.....	10
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	10
4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	10
Анхан шатны баримт бүрдүүлэлттэй холбоотой асуудал	10
5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ	10

1. ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 978-70433081, Факс: 978-70433081
E-mail: khovd@audit.gov.mn

2021.02.25 № 4/146
талай _____ -ны № _____ -т

ХОВД СУВРАГА ОНӨААТҮГ-ЫН ДАРГА

Л.ХАТАНБААТАР ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Ховд суврага ОНӨААТҮГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Ховд суврага ОНӨААТҮГ-ын оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан материаллаг алдаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, ард иргэдэд шашин номоор үйлчлэх үйлчилгээний хэрэгжилт зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

021020660

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АЛБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



БОЛДБАТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>27078776.1</u>	<u>19244646.0</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	16693925.3	10535663.2
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	16693925.3	10535663.2
3121	Төгрөг	16693925.3	10535663.2
31213	Арилжааны банк дахь харилцах	16693925.3	10535663.2
33	АВЛАГА	4740776.0	4760636.0
33401	Дансны авлага /ТӨҮГ/	535503.0	535503.0
335	Бусад авлага	4205273.0	4225133.0
3351	Байгууллагаас авах авлага	4205273.0	4225133.0
35	БАРАА МАТЕРИАЛ	5644074.8	3948346.8
354	Хангамжийн материал	5644074.8	3948346.8
35470	Бусад хангамжийн материал	5644074.8	3948346.8
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2928665574.0</u>	<u>2898270704.0</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2928665574.0	2898270704.0
392	Биет хөрөнгө	2553665574.0	2523270704.0
39201	Барилга, байгууламж, орон сууц	1273139544.0	1283139544.0
39202	Хуримтлагдсан элэгдэл	-39257670.0	-78515340.0
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	27198000.0	27728000.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	-17531100.0	-19140100.0
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12641900.0	13381900.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	-10200800.0	-10999000.0
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1306935200.0	1306935200.0
39214	Бусад үндсэн хөрөнгө	740500.0	740500.0
393	Биет бус хөрөнгө	375000000.0	375000000.0
39303	Бусад биет бус хөрөнгө	375000000.0	375000000.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2955744350.1</u>	<u>2917515350.0</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>7097000.0</u>	<u>7560718.2</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	7097000.0	7560718.2
413	Өглөг	7097000.0	7560718.2
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	4592000.0	3917000.0
4136	Бусад өглөг	2505000.0	3643718.2
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	5000.0	587898.2
41364	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/		555820.0
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	2500000.0	2500000.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2948647350.1</u>	<u>2909954631.8</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2948647350.1	2909954631.8
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3388294532.0	3399479532.0
51101	Өмч: - төрийн	1662621900.0	1662621900.0
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	1725672632.0	1736857632.0
512	Хуримтлагдсан үр дүн	-259585304.9	-309463023.2
51210	Өмнөх үеийн үр дүн	-259585304.9	-259585304.9
51220	Тайлант үеийн үр дүн		-49877718.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-180061877.0	-180061877.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2955744350.1</u>	<u>2917515350.0</u>

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	114921456.7	112396890.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	114921456.7	112396890.8
110	Орлогын албан татвар	114921456.7	112396890.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	114921456.7	112396890.8
110002	Үйл ажиллагааны орлого	114921456.7	112396890.8
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	163102687.3	162274609.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	163102687.3	162274609.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	163102687.3	162274609.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	163102687.3	162274609.1
210810	Борлуулалт, маркетингийн зардал /ТӨҮГ/		2679454.6
210813	Бусад зардал /ТӨҮГ/	163102687.3	159595154.5
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-48181230.6	-49877718.3
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-48181230.6	-49877718.3

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	113931923.5	101596333.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	93931923.5	81596333.8
120	Нийтлэг татварын бус орлого	93931923.5	81596333.8
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	92549488.8	80446963.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	92549488.8	80446963.0
120009	Бусад орлого	1382434.7	1149370.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	20000000.0	20000000.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	20000000.0	20000000.0
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	20000000.0	20000000.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	121031117.3	107754595.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	121031117.3	107754595.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	121031117.3	107754595.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	54757635.0	71169639.0
210101	Үндсэн цалин	54757635.0	71169639.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12935129.0	16379393.0
210201	Тэтгэврийн даатгал	12935129.0	16379393.0
2104	Хангамж, бараа материалын зардал	49907146.8	16186573.1
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	10245650.0	11246148.0
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	39661496.8	4940425.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3431206.5	4018990.8
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	3431206.5	4018990.8
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-7099193.8	-6158262.1

8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-7099193.8	-6158262.1
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	23793119.1	16693925.3
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	16693925.3	10535663.2

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,662,621,900.0	180,061,877.0	-259,585,304.9	1,725,672,632.0	2,948,647,350.1
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,662,621,900.0	180,061,877.0	-259,585,304.9	1,725,672,632.0	2,948,647,350.1
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,662,621,900.0	180,061,877.0	-259,585,304.9	1,725,672,632.0	2,948,647,350.1
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,662,621,900.0	180,061,877.0	-259,585,304.9	1,725,672,632.0	2,948,647,350.1
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,662,621,900.0	180,061,877.0	-259,585,304.9	1,725,672,632.0	2,948,647,350.1
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				11,185,000.0	11,185,000.0
D08	Тайлант үеийн үр дүн			-49,877,718.3		-49,877,718.3
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,662,621,900.0	180,061,877.0	-309,463,023.2	1,736,857,632.0	2,909,954,631.8

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Ховд суврага ОНӨААТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга Л.Хатанбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч анхан шатны баримтын бүрдүүлэлтийн талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 22-ноос 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Аззаяа хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Ховд Суврага ОНӨҮГазар нь “Шашны үйл ажиллагаа түүний удирдлага зохион байгуулалт менежмент, аялал жуулчлал, худалдаа үйлчилгээг таатай орчин нөхцөлөөр хангах” гэж байгууллагын үйл ажиллагааны зорилгоо тодорхойлжээ. Үүнд:

- Дээрх зорилго, зорилтын хүрээнд ажилчдынхаа ажлын байрыг бүрэн хадгалж шинэ үйлчилгээ, шинэ ажлын байр бий болгох, аймгийн төдийгүй баруун таван аймгийн хөдөлмөрчид, ахмадууд, хүүхэд залуучуудад соёлтой боловсон, чанартай үйлчилгээ үзүүлэхээр үйл ажиллагаатайгаа уялдуулан ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Ховд суврага ОНӨААТҮГ-ын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллага нь өөрийн онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж баталж мөрдөөгүй байна.

Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2020 онд тус байгууллагад дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 114921.5 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 1149.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 112396.9 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 1124.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Ховд суврага ОНААТҮГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 38229.0 мянган төгрөгөөр буюу 1.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	
Авлага	4740.7	4760.6	19.8	0.4%
Бараа материал	5644.0	3948.3	-1695.7	-30%
Үндсэн хөрөнгө	2928665.6	2898270.7	-30394.8	-1%

НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2955744.3	2917515.3	-38229.0	1.3%
Богино хугацаат өр төлбөр	7097.0	7560.7	463.7	6.5%
Цэвэр хөрөнгө, өмч	2948647.3	2909954.6	-38692.7	-1.3%
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2955744.3	2917515.3	-38229.0	-1.3%

Авлага дансны үлдэгдэл 4760.6 мянган төгрөг болж 19.8 мянган төгрөгөөр өссөн нь урд оны үүссэн ажиллагчдаас авах дансны авлага дээр 19.8 мянган төгрөгийн авлага үүссэнийг бүртгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 3948.3 мянган төгрөг болж 1695.7 мянган төгрөгөөр буурсан нь тайланд онд аж ахуйн материалын эцсийн үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 2928665.6 мянган төгрөг, оны эцэст 2898270.7 мянган төгрөг болж 30394.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн данс нь хандиваар 10000.0 мянган төгрөгийн барилга байгууламж, тоног төхөөрөмж 530.0, тавилга эд хогшил 655.0 мянган төгрөг өөрийн хөрөнгөөр 85.0 мянган төгрөгөөр бүгд 11270.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн ч элэгдлийн зардалтай холбоотой буурсан байна.

Өр төлбөр оны эхэнд 7097.0 мянган төгрөг ба үүний 2500.0 мянган төгрөг 2012 онд Гандантэгчлэн хийдээс зээлсэн, 2237.0 мянган төгрөг бусад байгууллага хувь хүнд өгөх материалын өглөг, 1680.0 мянган төгрөг нь Зэвсэгт хүчний 123-р ангид өгөх суврагын үнэ, 587.8 мянган төгрөгийн ХХОАТ, НДШ-ийн өр төлбөртэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2909954.6 мянган төгрөг болж тайлант онд 38692.7 мянган төгрөгөөр буурсан байгаа нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна.

Ховд суврага ОНӨААТҮГ-ын 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 2524.5 мянган төгрөгөөр буюу 7.8 хувиар өссөн нь үйл ажиллагааны орлого нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 3507.5 мянган төгрөгөөр буюу 7.8 хувиар буурсан, өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт үйл ажиллагааны зардал буурсантай холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй байна.

3.6. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 130 мэдээллээс хугацаандаа оруулсан 106 мэдээлэл байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянахад алдаа, зөрчил илэрсэнгүй.

3.7. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар авлага өглөг барагдуулах, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 1 зөвлөмж өгөгдсөнийг 50 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /сая.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	11.1	1	11.1	0	0	50
Нийт дүн	1	11.1	1	11.1	0	0	50

3.8. Аудитын илрүүлэлт

Аудитаар и баримтын бүрдлийг хангаж ажиллах давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа: Аудитаар залруулсан алдаа байхгүй болно.

Аудитын зөвлөмж: Аудитаар илэрсэн 1 алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХҮЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар авч үзэх онц асуудал байхгүй гэж үзлээ.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Анхан шатны баримт бүрдүүлэлттэй холбоотой асуудал

1.1 **Илрүүлэлт:** Тайлант онд худалдан авсан бараа бүтээгдэхүүн, гарсан зардлуудыг баримтжуулахдаа И баримтаар баталгаажуулаагүй байгаа нь борлуулагч талыг татвараас зайлсхийх боломжийг бий болгож байна.

Эрсдэл: Төсвийн зарцуулалтын хяналт сулрах, харилцагч байгууллага татвараас зайлсхийх

1.2 **Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Татварын ерөнхий хуулийн 28.5. “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаж, худалдан авалтын ажил гүйлгээ бүрийг И баримтаар баталгаажуулах.

1.3 **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 5 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	Ховд суврага ОНӨААТҮГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			ХОА-2021/03/СТА-ОНӨААН

Шалгагдсан
байгууллагын нэр:

Ховд суврага ОНӨААТҮГ

Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант онд худалдан авсан бараа бүтээгдэхүүн, гарсан зардлуудыг баримтжуулахдаа И баримтаар баталгаажуулаагүй	000	Зөвлөмж өгөх	Дарга, нягтлан бодогч	Л.Хатанбаатар, Б.Түмээ
	ДҮН	0.0			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР